



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/95

Халбан

Золбин нохой устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 42 дугаар тогтоол, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвд байгаа золбин болон айл өрхүүдийн нохой тэжээх тухай журмыг зөрчиж 07.00-23.00 цагийн хооронд уяж агдлаагүй нохойг устгах ажлыг 2024 оны 07дугаар сарын 26-ны өдрөөс 07 дугаар сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд Халбан баг, Бүрхээр багт зохион байгуулсугай.

2.Золбин нохой устгах ажлын зааварчилгаа, ажилтантай байгуулах гэрээ, шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Золбин нохой устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонбаяр (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: О.Ганхуяг (Засаг даргын Тамгын газрын жолооч)

М.Ренчиндорж (Засаг даргын Тамгын газрын Нярав)

Д.Отгонжаргал (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Нямдорж (Хэсгийн төлөөлөгч)

Ч.Сүхбат (Цагдаа)

Бүх багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Д.Мөнх-Эрдэнэ (Халбан багийн Засаг дарга)

4.Золбин нохой устгуулахаар сонгосон хүнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, галт зэвсэг хэрэглэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, унаа хэрэгслээр хангаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

5.Золбин нохой устгахад шаардлагатай төсвийг Засаг даргын нөөц сангаас гаргаж санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (М.Отгон-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

6.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.АНХБАЯР